Монголын бурханы шашин

Өнгөрсөн, одоо, ирээдүй

Өндөр гэгээн Занабазарын түмэн өлзий гийсний 380 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал

Хурлын өдрүүд:	2015 оны 4 дүгээр сарын 16–17
Хурлын байр:	Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургууль, Унгар Улс, 1088 Budapest, Múzeum körút 4/B
Илтгэл тавих хэл:	англи, монгол, орос
Зохион байгуулагчид:	Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургууль Монгол ба Төв Ази Судлалын Тэнхим Монгол Судлалын Төв Буддын шашны Судлалын Төв Унгарын Шинжлэх Ухааны Академи Хүмүүнлэгийн Ухааны Судалгааны Төв, Угсаатны Зүйн Судлалын Хүрээлэн

2015 оны 1-р сарын 31-ны дотор илтгэлийнхээ нэрийг Бирталан Агнеш (birtalan@hotmail.com), Телеки Кристина (krisztinateleki@yahoo.com) нарт э-мейлээр илгээнэ үү!

“Монголын бурханы шашин: өнгөрсөн, одоо, ирээдүй” хэмээх эрдэм шинжилгээний бага хурлын гол зорилго нь: Монголын бурханы шашны лам хувраг нар болон судлаачид нэг дор цуглаж өөрийн сонирхдог сэдвийн дагуу илтгэл айлтгал тавьж санал солилцоход оршино. Тухайлбал Монголын бурханы шашны түүх, гүн ухаан, урлаг, яруу найраг, ардын эмчилгээ, дахин сэргээсэн хийдүүдийн хурал ном, зан үйл, аж амьдрал, ардын шүтээх ёс, ёс заншил, бусад шашин, соёлын холбоо харилцаа, гэх мэт. Нийт монголчуудын бурханы шашны судалгааг хамарна (Халимаг, Буриад, Өвөр Монгол, бусад). Илтгэлийг англи, монгол, орос хэлээр тавьж болно. Тус бага хурал дээр тавьсан илтгэлийн хураангуйг ном эсвэл DVD-гээр хэвлэх болно. Цаашид Монголын бурханы шашны сэдвээр хамтарч ном бүтээхийг та бүхнээс гүнээ хүсэж байна.